



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 02 сарын 18 өдөр

Дугаар А/25

Шивээговь сум

Сумын Хүүхэд залуучуудын хөгжлийн дэд хөтөлбөрийг 2020 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.2, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2, 17.1.3, сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын Тэргүүлэгчдийн 2019 оны 94 дүгээр тогтоол, ИТХ-ын 2019 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн хуралдааны 11 дүгээр тогтоол “Сумын 2020 оны төсөв батлах тухай”-ыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Сумын Хүүхэд залуучуудын хөгжлийн дэд хөтөлбөрийг 2020 оны төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлсүгэй.
2. Сумын Хүүхэд залуучуудын хөгжлийн дэд хөтөлбөрийг 2020 онд хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.
3. Төлөвлөгөөний зардалд зарцуулагдах 10000000 /арван сая/ төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөс зарцуулахыг нягтлан бодогч /О.Дөлгөөн/-д зөвшөөрсүгэй.
4. Хөтөлбөрийг иргэдэд нээлттэй зохион байгуулж, санхүүгийн баримт бичгийн иж бүрдлийг ханган ажиллахыг Засаг даргын Тамгын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Б.Баасанбат/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



С.ЯГААНЦЭЦЭГ

D:\My Documents\zaxiramj.doc

4212 0062

Сумын Засаг даргын 2020 оны 02-р сарын 18-ны
 өдрийн 1125 дугаар захирамжийн хавсралт



СУМЫН ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ДЭД ХӨТӨЛБӨРИЙГ 2020 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Хөтөлбөрийн зорилт	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Хугацаа	Шалгуур үзүүлэлт	2020 онд хүрэх үр дүн	Шаардлагатай санхүүжилт	Хариуцах эзэн
1.		Хүүхдийн мэдээллийн санг бүрдүүлэх	1-р улиралд	2-18 насны хүүхдийн боловсролд хамрагдалт	- 100% - Мэдээллийн сан бүрдэж, боловсролд хамрагдалтын судалгааг гаргасан байна.	-	ЗДТГ ЕБС 3-р цэцэрлэг
2.	НЭГ. Хүүхдийн эрүүл аюулгүй, тав тухтай орчинд амьдрах боломжийг нэмэгдүүлж, нийгмийн бүхий л орчин дахь хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлнэ.	Хүүхэд, залуучуудын бие бялдрын хөгжил, чийрэгжилтийн түвшинг тогтоох сорил зохион байгуулах	Жилд 1 удаа	Хамрагдалтын хувь	- 30-аас доошгүй хувь - Сорилын үр дүнг тооцсон байна.	-	ЗДТГ ЕБС
3.	хүүхдийн эсрэг хүчирхийллээс урьдчилан сэргийлнэ.	Гэр бүл, хүүхэд хамгааллын "Хамтарсан баг"-ийн үйл ажиллагааг зохион байгуулах	Жилдээ	Хамтарсан багийн үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт	- 100% - Монгол улсын Хүүхдийн эрхийн тухай хууль, "Хүүхэд хамгааллын тухай хууль, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийг хангасан байна.	550,000	Сумын Хамтарсан баг

4.	Хоёр. Хүүхэд бүрийн сурч хөгжих, оролцох боломжийг бүрдүүлж, хүүхдийн хөгжлийг бүхий л талаар дэмжсэн эерэг харилцаатай гэр бүлийг төлөвшүүлнэ.	Хүүхдийн номын сангийн фондыг нэмэгдүүлэх	4-р сард	Номны тоо ширхэг	- 150 ширхэг - Хүүхдийн номыг нэмэгдүүлж, уншигчдын тоо нэмэгдсэн байна.	1,200,000	ЗДТГ Соёлын төв
5.		Угийн бичиг хөтлөлтийг эрчимжүүлэх ажлыг зохион байгуулах	Жилдээ	Сумын иргэдийн хамрагдалт	- 20 хувиас доошгүй - Угийн бичиг хөтөлдөг өрхийн тоог нэмэгдүүлсэн байна.	-	Соёлын төв
6.		Хүүхдийн оюун ухааныг хөгжүүлэх сургалтын хэрэглэгдэхүүнээр хангах	4-р сард	Цэцэрлэгийн сургалтын хэрэглэгдэхүүнийг нэмэгдүүлэх	Хүүхдийн хөгжлийг дэмжиж, сургалтын орчныг бүрдүүлсэн байна.	1,450,000	ЗДТГ 3-р цэцэрлэг
7.		Хүүхэд багачуудын дунд урлагийн арга хэмжээ зохион байгуулах	6 сард	Тоглолтын тоо	- 1 удаа - Хүүхдийн авьяасыг сурталчилсан байна.	223,500	ЗДТГ Соёлын төв
8.		Гэр бүл, хүүхдэд зөвлөгөө өгөх төрийн бус байгууллагатай хамтран ажиллах	Жилдээ	Сэтгэл зүйн үйлчилгээг үзүүлэх тоо	- 1 удаа	300,000	ЗДТГ
9.	ГУРАВ. Залуучуудын эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, эрүүл амьдрах зөв дадлыг эзэмшүүлнэ.	Өсвөр насны хүүхдүүдэд халдварт өвчлөлөөс урьдчилан сэргийлэх эрүүл мэндийн үзлэгийг зохион байгуулж, мэдлэг олгох	Жилдээ	ЕБС-ийн 6-12 дугаар ангийн сурагчдын хамрагдалт	- 100% - Эрүүл зан үйлд төлөвших мэдлэгийг олгож, эрүүл мэндийн үзлэгт хамруулсан байна.	850,000	ЭМТ ЕБС
10.		Өсвөр насны охидын үзлэгийг зохион байгуулах	2-р улиралд	Өсвөр насны охидын хамрагдалт	- 100% - Эрүүл мэндийн зөв дадалд суралцсан байна.	-	ЭМТ ЕБС
11.		"Гэр бүл	3-р сард	Хамрагдах	- 15-18 насны	100,000	ЭМТ

		төлөвлөлт" сургалт зохион байгуулах		залуучуудын хувь	өсвөр насны хүүхэд 100%		ЕБС	
12.	ДӨРӨВ. Залуучуудын мэдлэг боловсролыг дээшлүүлж, хөдөлмөр эрхлэлтийг дэмжинэ.	Сумын залуучуудын судалгааг нарийвчлан гаргах	1-р улиралд	15-34 насны залуучуудын судалгаанд хамрагдалт	- 100% - Нэгдсэн мэдээллийн сан бүрдсэн байна.	-	ЗДТГ	
13.		Мэргэжлийн чиг баримжаа олгох сургалт зохион байгуулах	9-р сард	9-12 дугаар ангийн сурагчдын хамрагдалт	- 100% - Мэргэжлээ зөв сонгох мэдлэг, мэдээлэлтэй болсон байна.	200,000	Залуучуудын хөгжлийн салбар зөвлөл	
14.		Залуучуудын чуулга уулзалт зохион байгуулах	3-р сард	Залуучуудын хамрагдалтын хувь	- 30%-аас доошгүй - Залуучуудын идэвх оролцоог нэмэгдүүлсэн байна.	2,590,000	Залуучуудын хөгжлийн салбар зөвлөл	
15.		Малчин залууст чиглэсэн соёл, спортын арга хэмжээ зохион байгуулах	Жилдээ	Зохион байгуулах арга хэмжээний тоо - 1	Малчин залуусын 30-аас доошгүй хувийг хамруулсан байна.	400,000	ЗДТГ	
16.		Монгол хэл бичгийн сургалт зохион байгуулах	Жилдээ	Хамрагдах төрийн албан хаагчдын тоо - 50	Төрийн албан хаагчдын Монгол бичгийн чадвар нэмэгдэнэ.	-	ЗДТГ ЕБС	
17.		Монгол хэл бичгийн олимпиад зохион байгуулах	4-р сард	Иргэдийн 3 насны ангилалаар хийгдэнэ.	Иргэдийн нийгмийн идэвхийг нэмэгдүүлсэн байна.	548,000	ЗДТГ ЕБС	
18.		ТАВ. Хүүхэд, залуучуудын нийгмийн оролцоо, манлайлалыг нэмэгдүүлнэ.	Спортын тэмцээн зохион байгуулах	3 сард	15-34 насны залуучуудын хамрагдалт	- 30-аас доошгүй хувийг хамруулах - Нийгмийн оролцоо сайжирсан байна.	972,000	Залуучуудын хөгжлийн салбар зөвлөл
19.			Сумын шагайн харвааны аварга шалгаруулах	4-р сард	Оролцогчдын тоог өмнөх оноос 10%-	Төрийн болон төрийн бус байгууллагын	162,000	Сумын шагайн харвааны

	тэмцээн зохион байгуулах		аар нэмэгдүүлэх	хамтын ажиллагаа, уялдаа, холбоо сайжирсан байна.		холбоо
20	“Архигүй баяр” уриалга гаргах уралдаан зохион байгуулж, олон нийтэд нөлөөллийн ажлыг өрнүүлэх	03 сард	Хүүхдийн дуу хоолойг нийгэмд хүргэсэн байх	Тэмдэглэлт баяраар нөлөөллийн ажил зохион байгуулсан байна.	-	ЗДТГ
21.	“Оны шилдэг залуу”-г шалгаруулж, алдаршуулах	4-р улиралд	Шалгаруулах номинаци - 5	Залуучуудын нийгмийн идэвх оролцоо, амжилтыг ил тод мэдээлсэн байна.	454,500	ЗДТГ
Нийт дүн					10,000,000	

ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЯНАСАН:
 ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН
 ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ:

Б.БААСАНБАТ

ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛСАН:
 НИЙГМИЙН БОДЛОГЫН МЭРГЭЖИЛТЭН:

З.БААСАНДАЛАЙ